



2018. оны 01 сарын 11. өдөр

Дугаар 01.

Улаанбаатар хот

“ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дүрэм”-д
өөрчлөлт оруулах тухай

“ШУТИС-ийн дүрэм”-ийн 4.3, 4.4, 4.6 дах заалтууд, Эрдмийн зөвлөлийн гишүүдийн Нээлттэй санал хураалтын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дүрэм”-ийн 2.1, 2.2, 4.1.5, 5.1, 5.2, 5.3, 6.1 заалтуудад хавсралтад заасан засвар өөрчлөлтийг оруулан баталж, Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллахыг Эрдмийн зөвлөлийн дарга Б.Очирбат, гишүүдэд үүрэг болгосугай.
2. “ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дүрэм”-д оруулсан өөрчлөлтийг батлагдсан өдрөөс нь эхлэн мөрдсүгэй.

Зөвлөлийн дарга

Зөвлөлийн нарийн бичгийн дарга



Б.Очирбат

Т.Намнан

ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2018 оны
01 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны
01 дүгээр тогтоолын Хавсралт



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн (цаашид ШУТИС гэх) Эрдмийн зөвлөл нь Монгол улсын Дээд боловсролын тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Технологийн дамжуулалтын тухай хууль, Инновацийн тухай хууль ба түүнтэй холбогдох дүрэм, журам, ШУТИС-ийн дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.
- 1.2. Эрдмийн зөвлөл нь сургалт, судалгаа, инновацийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, хөгжүүлэх чиглэл, бодлого, зорилтыг тодорхойлох, түүний хэрэгжилтийн явц, үр дүнг хэлэлцэж санал, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрдмийн болон хүндэт цол олгох зэргээр ШУТИС-ийг мэргэжлийн удирдлагаар хангана.

Хоёр. Эрдмийн зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт

- 2.1. Эрдмийн зөвлөлийг их сургуулийн Захирал удирдана. Эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн даргаар Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирлыг томилон ажиллуулна.
- 2.2. Эрдмийн зөвлөл нь ШУТИС-ийн Бүрэлдэхүүн болон харьяа нэгжүүдийн оролцоог хангах эрдмийн зэрэг цолтой, тэргүүлэх эрдэмтэн судлаачдын төлөөллөөс бүрдэх ба бүрэлдэхүүнийг Захирлын тушаалаар батална.
- 2.3. Эрдмийн зөвлөлийн дүрмийг Эрдмийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн баталж мөрдөнө.
- 2.4. Эрдмийн зөвлөл нь их сургуулийн удирдах үйл ажиллагаанд профессор багш нарын оролцох эрх мэдлийг өргөжүүлэх зорилгоор чиг үүргийн цар хүрээ, онцлогоос хамаарч эрх мэдлийн хуваарилалтыг хэрэгжүүлэх байнгын ажиллагаатай дэд зөвлөлүүдтэй байж болно.
- 2.5. Бүрэлдэхүүн сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэн нь Эрдмийн зөвлөлтэй байна.

Гурав. Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагаа

- 3.1. Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь нийт гишүүдийн хуралдаан байна.
- 3.2. Эрдмийн зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 3.2.1. Их сургуулийн хөгжлийн бодлого, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, технологи дамжуулах хөтөлбөр боловсруулж батлуулах
 - 3.2.2. Эрдэм шинжилгээний ажлын талаар баримтлах бодлого, чиглэл, үр дүнг хэлэлцэж батлуулах;
 - 3.2.3. Сургалтын бодлого, технологийн холбогдолтой баримт бичиг, зохион байгуулалт, үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулах;



ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2018 оны
01 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны
01 дүгээр тогтоолын Хавсралт

- 3.2.4. Профессорын баг, тэнхим байгуулах, нэгтгэх, өөрчлөн зохион байгуулах, татан буулгах талаар санал, дүгнэлт гаргах;
- 3.2.5. Профессор, дэд профессор, хүндэт доктор цол олгох асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргах
- 3.2.6. Байнгын ажиллагаатай дэд зөвлөлүүдийн санал, дүгнэлтийг хэлэлцэж шийдвэр гаргах;
- 3.2.7. Сургуулийн үндсэн үйл ажиллагааг зохицуулах нийтлэг дүрэм, эрх зүйн бусад баримт бичгийг хэлэлцэн батлах;
- 3.2.8. Сургуулийн удирдлагын тайланг хэлэлцэж, үнэлэлт, дүгнэлт өгөх;
- 3.2.9. Эрдмийн зөвлөл нь гишүүний дэвшүүлсэн асуудлыг холбогдох дэд зөвлөл дэмжсэн тохиолдолд хэлэлцэн шийдвэр, дүгнэлт гаргах.

Дөрөв. Эрдмийн зөвлөлийн гишүүний эрх, үүрэг

- 4.1. Эрдмийн зөвлөлийн гишүүн дараах бүрэн эрхийг эдэлнэ.
 - 4.1.1. Эрдмийн зөвлөлд хэлэлцсэн асуудлаар санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх;
 - 4.1.2. Эрдмийн зөвлөлөөр хэлэлцэж буй асуудлыг шийдвэрлэхэд таслах эрхтэй оролцох;
 - 4.1.3. Сургуулийн үйл ажиллагаатай шууд холбоотой аливаа асуудлыг Эрдмийн зөвлөлд хэлэлцүүлэхээр санал оруулах;
 - 4.1.4. Эрдмийн зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавих, шалгах, ажлын хэсэгт оролцох;
 - 4.1.5. Сургуулийн хэмжээний аливаа асуудлаар эрдмийн зөвлөлийн дарга болон холбогдох дэд захирал, бүрэлдэхүүн сургууль болон хүрээлэнгийн захиралд асуудлыг шууд тавьж шийдвэрлүүлэх;
 - 4.1.6. Эрдмийн зөвлөлийн гишүүнээс өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх;
 - 4.1.7. Эрдмийн зөвлөлийн гишүүний ёслолын өмсгөл хэрэглэх;
- 4.2. Эрдмийн зөвлөлийн гишүүн дараах үүргийг хүлээнэ.
 - 4.2.1. Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагаанд биеэр оролцох;
 - 4.2.2. Эрдмийн зөвлөлийн гишүүний хувьд өгсөн аливаа үүрэг даалгаврыг биелүүлэх;
 - 4.2.3. Өөрийн сургууль дээр Эрдмийн зөвлөлийн шийдвэрийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах талаар санаачилга гаргах, биечлэн оролцох.

Тав. Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Байнгын ажиллагаатай дэд зөвлөлүүд

- 5.1. Эрдмийн зөвлөл нь дараах байнгын ажиллагаатай дэд зөвлөлүүдтэй байна.
 - 5.1.1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн дэд зөвлөл
 - 5.1.2. Эрдмийн ба хүндэт цолны дэд зөвлөл
 - 5.1.3. Эрдэм шинжилгээ, инноваци, хамтын ажиллагааны дэд зөвлөл
 - 5.1.4. Сургалт, оюутны хөгжлийн дэд зөвлөл
 - 5.1.5. Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын дэд зөвлөл

ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2018 оны
01 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны
01 дүгээр тогтоолын Хавсралт



- 5.2. Байнгын ажиллагаатай дэд зөвлөлүүдийн бүрэлдэхүүн удирдлагыг Захирлын тушаалаар батална.
- 5.3. Байнгын ажиллагаатай дэд зөвлөлүүд нь үйл ажиллагааны хамрах хүрээнд дэвшүүлсэн асуудлаар санал, дүгнэлт, зөвлөмж гаргаж Эрдмийн зөвлөл болон Захирлын зөвлөлд уламжлан хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.
- 5.4. Дэд зөвлөлүүдийг шинээр байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

Зургаа. Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн Эрдмийн зөвлөл

- 6.1. ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийг тухайн сургууль, хүрээлэнгийн захирал удирдана. Эрдмийн зөвлөлд тухайн сургууль, хүрээлэнгийн болон салбарын нэр хүнд бүхий тэргүүлэх эрдэмтдийг оруулах ба бүрэлдэхүүнийг Захирлын тушаалаар батална.
- 6.2. Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн Эрдмийн зөвлөл нь эрдэмтэн нарийн бичгийн даргатай байна.
- 6.3. Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн Эрдмийн зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 6.3.1. Сургууль, хүрээлэнгийн хөгжлийн өнөөгийн байдал ба хэтийн төлөв, бүтэц, зохион байгуулалт, эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийг тогтоох зэрэг асуудлыг хэлэлцэн зөвлөмж, шийдвэр гаргах,
 - 6.3.2. Салбарын сургалт, эрдэм шинжилгээний ажлын тайланг жил бүр хэлэлцэн дүгнэлт өгөх, цаашдын зорилго, чиглэлийг тодорхойлох,
 - 6.3.3. Сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулах, шинэ хөтөлбөр батлах талаар ирүүлсэн саналыг авч хэлэлцэн дүгнэлт гаргах,
 - 6.3.4. Салбарын эрдэмтдийн эрдэм шинжилгээний шилдэг бүтээл шалгаруулах, дээд байгууллагын шагналд эрдэмтэд, эрдмийн хамтлагийн бүтээлийг хэлэлцэн дэвшүүлэх,
 - 6.3.5. Сургуулийн хэмжээнд хэрэгжиж буй эрдэм шинжилгээний ажлын явц, үр дүнг тогтмол хэлэлцэн үнэлэлт дүгнэлт өгөх,
 - 6.3.6. Салбарын эрдэмтдийн боловсруулсан эрдэм шинжилгээний төсөл, сэдэвт ажлын саналыг хэлэлцэн дүгнэлт гаргах,
 - 6.3.7. Тухайн нэгжийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлттэй холбоотой саналыг хүлээн авч, санал, дүгнэлт гаргах,
 - 6.3.8. Ахисан түвшний судалгааны ажлын чиглэл, сэдвийг хэлэлцэн батлах,
 - 6.3.9. Докторын зэрэг горилсон бүтээлийн урьдчилсан хамгаалалт хийлгэж, дүгнэлт гаргах,
 - 6.3.10. Профессор, дэд профессор, хүндэт доктор, хүндэт профессор цол олгох саналыг авч хэлэлцэн дүгнэлт гаргах,
 - 6.3.11. Багш нарт бүтээлийн чөлөө олгох асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргах, үр дүнг хэлэлцэж дүгнэлт гаргах
- 6.4. Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн Эрдмийн зөвлөл хэлэлцсэн асуудлаар шийдвэр гаргаж, тэмдэглэл хэлбэрээр баталгаажуулна.

ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2018 оны
01 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны
01 дүгээр тогтоолын Хавсралт



Долоо. Эрдмийн зөвлөлийн хуралдаан, хуралдааны дэг, шийдвэр гаргах

- 7.1. Эрдмийн зөвлөл хуралдааныг бүх гишүүдийн 75 хувиас доошгүй ирцтэй хийнэ.
- 7.2. Хуралдаанаар хэлэлцэх асуудал, шийдвэрийн төсөл зэрэг холбогдох бичиг баримтыг хурал эхлэхээс 3-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд мэдээлнэ.
- 7.3. Эрдмийн зөвлөл хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргаж, тэмдэглэл хөтлөх ба эрдмийн цол олгохоос бусад асуудлыг илээр санал хурааж шийдвэрлэнэ.
- 7.4. Гадаадын иргэнд хүндэт цол олгох асуудлыг ил санал хураалтаар шийдвэрлэнэ.
- 7.5. Эрдмийн зөвлөлийн санал хураалтад оролцсон гишүүдийн 75 ба түүнээс дээш хувь нь зөвшөөрсөн үед тухайн хэлэлцсэн асуудал дэмжигдэн шийдвэрлэгдсэнд тооцно.
- 7.6. Эрдмийн зөвлөлийн хуралдааны тогтоолд Зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурна.
- 7.7. Эрдмийн зөвлөлийн дэргэдэх дэд зөвлөл болон бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн эрдмийн зөвлөлийн хуралдаанд энэхүү дэгийг ерөнхийд нь баримтална.



ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2012 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталж, 2014 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны 14 дүгээр тогтоолын хавсралтаар нэмэлт өөрчлөлт оруулсан

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн (цаашид ШУТИС гэх) Эрдмийн зөвлөл нь Монгол улсын Дээд боловсролын тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Технологийн дамжуулалтын тухай хууль, Инновацийн тухай хууль ба түүнтэй холбогдох дүрэм, журам, ШУТИС-ийн дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.
- 1.2. Эрдмийн зөвлөл нь сургалт, судалгаа, инновацийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, хөгжүүлэх чиглэл, бодлого, зорилтыг тодорхойлох, түүний хэрэгжилтийн явц, үр дүнг хэлэлцэж санал, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрдмийн болон хүндэт цол олгох зэргээр ШУТИС-ийг мэргэжлийн удирдлагаар хангана.

Хоёр. Эрдмийн зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт

- 2.1. Эрдмийн зөвлөлийг их сургуулийн Ректор удирдана. Эрдмийн зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн даргаар Эрдэм шинжилгээ, технологийн проректорыг томилон ажиллуулна.
- 2.2. Эрдмийн зөвлөл нь ШУТИС-ийн бүрэлдэхүүн болон харъяа нэгжүүдийн оролцоог хангах эрдмийн зэрэг цолтой, тэргүүлэх эрдэмтэн судлаачдын төлөөллөөс бүрдэх ба бүрэлдэхүүнийг Ректорын тушаалаар батална.
- 2.3. Эрдмийн зөвлөлийн дүрмийг Эрдмийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн баталж мөрдөнө.
- 2.4. Эрдмийн зөвлөл нь их сургуулийн удирдах үйл ажиллагаанд профессор багш нарын оролцох эрх мэдлийг өргөжүүлэх зорилгоор чиг үүргийн цар хүрээ, онцлогоос хамаарч эрх мэдлийн хуваарилалтыг хэрэгжүүлэх байнгын ажиллагаатай дэд зөвлөлүүдтэй байж болно.
- 2.5. Бүрэлдэхүүн сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэн нь Эрдмийн зөвлөлтэй байна.

Гурав. Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагаа

- 3.1. Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь нийт гишүүдийн хуралдаан байна.
- 3.2. Эрдмийн зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 3.2.1. Их сургуулийн хөгжлийн бодлого, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, технологи дамжуулах хөтөлбөр боловсруулж батлуулах
 - 3.2.2. Эрдэм шинжилгээний ажлын талаар баримтлах бодлого, чиглэл, үр дүнг хэлэлцэж батлуулах;
 - 3.2.3. Сургалтын бодлого, технологийн холбогдолтой баримт бичиг, зохион байгуулалт, үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулах;
 - 3.2.4. Профессорын баг, тэнхим байгуулах, нэгтгэх, өөрчлөн зохион байгуулах, татан буулгах талаар санал, дүгнэлт гаргах;
 - 3.2.5. Профессор, дэд профессор, хүндэт доктор цол олгох асуудлыг хэлэлцэн

шийдвэр гаргах

3.2.6. Байнгын ажиллагаатай дэд зөвлөлүүдийн санал, дүгнэлтийг хэлэлцэж шийдвэр гаргах;

3.2.7. Сургуулийн үндсэн үйл ажиллагааг зохицуулах нийтлэг дүрэм, эрх зүйн бусад баримт бичгийг хэлэлцэн батлах;

3.2.8. Сургуулийн удирдлагын тайланг хэлэлцэж, үнэлэлт, дүгнэлт өгөх

3.2.9. Эрдмийн зөвлөл нь гишүүний дэвшүүлсэн асуудлыг холбогдох дэд зөвлөл дэмжсэн тохиолдолд хэлэлцэн шийдвэр, дүгнэлт гаргах



Дөрөв. Эрдмийн зөвлөлийн гишүүний эрх, үүрэг

4.1. Эрдмийн зөвлөлийн гишүүн дараах бүрэн эрхийг эдэлнэ.

4.1.1. Эрдмийн зөвлөлд хэлэлцсэн асуудлаар санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх;

4.1.2. Эрдмийн зөвлөлөөр хэлэлцэж буй асуудлыг шийдвэрлэхэд таслах эрхтэй оролцох;

4.1.3. Сургуулийн үйл ажиллагаатай шууд холбоотой аливаа асуудлыг Эрдмийн зөвлөлд хэлэлцүүлэхээр санал оруулах;

4.1.4. Эрдмийн зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавих, шалгах, ажлын хэсэгт оролцох;

4.1.5. Сургуулийн хэмжээний аливаа асуудлаар эрдмийн зөвлөлийн дарга болон холбогдох проректор, бүрэлдэхүүн сургууль болон хүрээлэнгийн захиралд асуудлыг шууд тавьж шийдвэрлүүлэх;

4.1.6. Эрдмийн зөвлөлийн гишүүнээс өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх;

4.1.7. Эрдмийн зөвлөлийн гишүүний ёслолын өмсгөл хэрэглэх;

4.2. Эрдмийн зөвлөлийн гишүүн дараах үүргийг хүлээнэ.

4.2.1. Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагаанд биеэр оролцох;

4.2.2. Эрдмийн зөвлөлийн гишүүний хувьд өгсөн аливаа үүрэг даалгаврыг биелүүлэх;

4.2.3. Өөрийн сургууль дээр Эрдмийн зөвлөлийн шийдвэрийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах талаар санаачлага гаргах, биечлэн оролцох;

Тав. Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Байнгын ажиллагаатай дэд зөвлөлүүд

5.1. Эрдмийн зөвлөл нь дараах байнгын ажиллагаатай дэд зөвлөлүүдтэй байна.

5.1.1. Хөгжлийн бодлого, эрдмийн ба хүндэт цолны дэд зөвлөл

5.1.2. Эрдэм шинжилгээ, инновацийн дэд зөвлөл

5.1.3. Сургалтын бодлого, номын сан, сургалтын материалын дэд зөвлөл

5.1.4. Санхүү, эдийн засгийн дэд зөвлөл

5.1.5. Хамтын ажиллагаа, нийгмийн түншлэл, оюутны хөгжлийн дэд зөвлөл

5.2. Байнгын ажиллагаатай дэд зөвлөлүүдийн бүрэлдэхүүн, удирдлагыг Ректорын тушаалаар батална.

5.3. Байнгын ажиллагаатай дэд зөвлөлүүд нь үйл ажиллагааны хамрах хүрээнд дэвшүүлсэн асуудлаар санал, дүгнэлт, зөвлөмж гаргаж Эрдмийн зөвлөл болон Ректорын зөвлөлд уламжлан хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.

5.4. Дэд зөвлөлүүдийг шинээр байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

Зургаа. Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн Эрдмийн зөвлөл


6.1. ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Эрдмийн

зөвлөлийг тухайн сургууль, хүрээлэнгийн захирал удирдана. Эрдмийн зөвлөлд тухайн сургууль, хүрээлэнгийн болон салбарын нэр хүнд бүхий тэргүүлэх эрдэмтдийг оруулах ба бүрэлдэхүүнийг Ректорын тушаалаар батална.

- 6.2. Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн Эрдмийн зөвлөл нь эрдэмтэн нарийн бичгийн даргатай байна.
- 6.2. Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн Эрдмийн зөвлөл нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 6.2.1. Сургууль, хүрээлэнгийн хөгжлийн өнөөгийн байдал ба хэтийн төлөв, бүтэц, зохион байгуулалт, эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийг тогтоох зэрэг асуудлыг хэлэлцэн зөвлөмж, шийдвэр гаргах,
- 6.2.2. Салбарын сургалт, эрдэм шинжилгээний ажлын тайланг жил бүр хэлэлцэн дүгнэлт өгөх, цаашдын зорилго, чиглэлийг тодорхойлох,
- 6.2.3. Сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулах, шинэ хөтөлбөр батлах талаар ирүүлсэн саналыг авч хэлэлцэн дүгнэлт гаргах,
- 6.2.4. Салбарын эрдэмтдийн эрдэм шинжилгээний шилдэг бүтээл шалгаруулах, дээд байгууллагын шагналд эрдэмтэд, эрдмийн хамтлагийн бүтээлийг хэлэлцэн дэвшүүлэх,
- 6.2.5. Сургуулийн хэмжээнд хэрэгжиж буй эрдэм шинжилгээний ажлын явц, үр дүнг тогтмол хэлэлцэн үнэлэлт дүгнэлт өгөх,
- 6.2.6. Салбарын эрдэмтдийн боловсруулсан эрдэм шинжилгээний төсөл, сэдэвт ажлын саналыг хэлэлцэн дүгнэлт гаргах,
- 6.2.7. Тухайн нэгжийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтэй холбоотой саналыг хүлээн авч, санал, дүгнэлт гаргах,
- 6.2.8. Ахьсан түвшний судалгааны ажлын чиглэл, сэдвийг хэлэлцэн батлах,
- 6.2.9. Докторын зэрэг горилсон бүтээлийн урьдчилсан хамгаалалт хийлгэж, дүгнэлт гаргах,
- 6.2.10. Профессор, дэд профессор, хүндэт доктор, хүндэт профессор цол олгох саналыг авч хэлэлцэн дүгнэлт гаргах,
- 6.2.11. Багш нарт бүтээлийн чөлөө олгох асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргах, үр дүнг хэлэлцэж дүгнэлт гаргах
- 6.3. Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн Эрдмийн зөвлөл хэлэлцсэн асуудлаар шийдвэр гаргаж, тэмдэглэл хэлбэрээр баталгаажуулна.

Долоо. Эрдмийн зөвлөлийн хуралдаан, хуралдааны дэг, шийдвэр гаргах

- 7.1. Эрдмийн зөвлөл хуралдаанаа бүх гишүүдийн 75 хувиас доошгүй ирцтэй хийнэ.
- 7.2. Хуралдаанаар хэлэлцэх асуудал, шийдвэрийн төсөл зэрэг холбогдох бичиг баримтыг хурал эхлэхээс 3-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд мэдээлнэ.
- 7.3. Эрдмийн зөвлөл хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргаж, тэмдэглэл хөтлөх ба эрдмийн цол олгохоос бусад асуудлыг илээр санал хурааж шийдвэрлэнэ.
- 7.4. Гадаадын иргэнд хүндэт цол олгох асуудлыг ил санал хураалтаар шийдвэрлэнэ.
- 7.5. Эрдмийн зөвлөлийн санал хураалтад оролцсон гишүүдийн 75 ба түүнээс дээш хувь нь зөвшөөрсөн үед тухайн хэлэлцсэн асуудал дэмжигдэн шийдвэрлэгдсэнд тооцно.
- 7.6. Эрдмийн зөвлөлийн хуралдааны тогтоолд Зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурна.
- 7.7. Эрдмийн зөвлөлийн дэргэдэх дэд зөвлөл болон бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн эрдмийн зөвлөлийн хуралдаанд энэхүү дэгийг ерөнхийд нь баримтална.





ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2014
оны дугаар сарын өдрийн тоот
тогтоолын хавсралт

5.1.5. Хамтын ажиллагаа, нийгмийн түншлэл, оюутны хөгжлийн дэд зөвлөл» гэж өөрчлөх.

5. 7.6. зүйлд «Эрдмийн зөвлөлийн хуралдааны тогтоолд Зөвлөлийн дарга гарын үсэг зурна» гэснийг «Эрдмийн зөвлөлийн хуралдааны тогтоолд Зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурна» гэж шинэчлэн найруулах.



2014 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

**“ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дүрэм”-д холбогдох
засвар өөрчлөлтийг оруулах тухай.**

“ШУТИС-ийн дүрэм”-ийн 4.3, 4.4, 4.6 дах заалтууд, Эрдмийн зөвлөлийн гишүүдийн Нээлттэй санал хураалтын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дүрэм”-ийн 1.2, 2.1, 2.2., 5.1., 7.6 дах заалтуудад хавсралтад заасан засвар өөрчлөлтийг оруулан баталж, Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллахыг Эрдмийн зөвлөлийн дарга, Ректор Б.Очирбатад үүрэг болгосугай.
2. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь эхэлж мөрдсүгэй.

Зөвлөлийн дарга

Зөвлөлийн нарийн бичгийн дарга



Б.Очирбат

Ч.Баасандаш



**“ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН
ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ”-д ОРУУЛАХ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ**

1. 1.2. зүйлд «Эрдмийн зөвлөл нь эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох, хөгжүүлэх бодлого, зорилт чиглэлийг тодорхойлох, түүний үр дүнг хэлэлцэж санал, дүгнэлт, зөвлөмж гаргах зэргээр Их сургуулийг мэргэжлийн удирдлагаар хангана.» гэснийг «Эрдмийн зөвлөл нь сургалт, судалгаа, инновацийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, хөгжүүлэх чиглэл, бодлого, зорилтыг тодорхойлох, түүний хэрэгжилтйн явц, үр дүнг хэлэлцэж санал, дүгнэлт, зөвлөмж, шийдвэр гаргах, эрдмийн болон хүндэт цол олгох зэргээр ШУТИС-ийг мэргэжлийн удирдлагаар хангана.» гэж шинэчлэн найруулах.
2. 2.1. зүйлд «Эрдмийн зөвлөлийг их сургуулийн Ректор удирдана. Эрдмийн зөвлөлийн дэд даргаар Эрдэм шинжилгээ, технологийн проректор, эрдэмтэн нарийн бичгийн даргаар Эрдэм шинжилгээ, технологийн газрын даргыг тус тус томилон ажиллуулна.» гэснийг «Эрдмийн зөвлөлийг их сургуулийн Ректор удирдана. Эрдмийн зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн даргаар Эрдэм шинжилгээ, технологийн проректорыг томилон ажиллуулна.» гэж шинэчлэн найруулах.
3. 2.2. зүйлд «Эрдмийн зөвлөл нь проректор, газар, төвийн дарга, эрхлэгч, бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн захирал, профессор, салбарын тэргүүлэх эрдэмтдийн төлөөллөөс бүрдэх ба бүрэлдэхүүнийг Ректорын тушаалаар батална» гэснийг «Эрдмийн зөвлөл нь ШУТИС-ийн бүрэлдэхүүн болон харьяа нэгжүүдийн оролцоог хангах эрдмийн зэрэг цолтой, тэргүүлэх эрдэмтэн судлаачдын төлөөллөөс бүрдэх ба бүрэлдэхүүнийг Ректорын тушаалаар батална» гэж шинэчлэн найруулах.
4. 5.1. зүйлд «Эрдмийн зөвлөл нь дараах байнгын ажиллагаатай дэд зөвлөлүүдтэй байна.
 - 5.1.1. Сургуулийн хөгжлийн бодлогын дэд зөвлөл
 - 5.1.2. Эрдэм шинжилгээ, судалгааны дэд зөвлөл
 - 5.1.3. Сургалтын бодлого, технологи, арга зүйн дэд зөвлөл
 - 5.1.4. Гадаад харилцаа хамтын ажиллагааны дэд зөвлөл
 - 5.1.5. Санхүү, Эдийн засаг, нийгмийн хөгжлийн дэд зөвлөл
 - 5.1.6. Эрдмийн ба хүндэт цолны дэд зөвлөл
 - 5.1.7. Номын сан, сургалтын материалын дэд зөвлөл
 - 5.1.8. Оюуны өмчийн бодлогын дэд зөвлөл»гэснийг
«Эрдмийн зөвлөл нь дараах байнгын ажиллагаатай дэд зөвлөлүүдтэй байна.
 - 5.1.1. Хөгжлийн бодлого, эрдмийн ба хүндэт цолны дэд зөвлөл
 - 5.1.2. Эрдэм шинжилгээ, инновацийн дэд зөвлөл
 - 5.1.3. Сургалтын бодлого, номын сан, сургалтын материалын дэд зөвлөл
 - 5.1.4. Санхүү, эдийн засгийн дэд зөвлөл